



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн “Энэрэнгүй сэтгэл” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/074/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>НТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Г. Нандинжаргал Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х. Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayrkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С. Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantuguss@audit.gov.mn</p> <p>“Ирмүүн хантайшир аудит” ХХК-ийн захирал: Д. Бямбацэрэн Утас: 77550809 Цахим хаяг: irmuukhantaishir@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭЖЛИЙН АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.12.15 № 936
танай _____ -ны № _____ -т

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРГИЙН ЭНЭРЭНГҮЙ СЭТГЭЛ
ӨЭМТ-ИЙН ДАРГА УАЛТАНТУУЛ
ТАНАА**

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн "Энэрэнгүй сэтгэл" ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Энэрэнгүй сэтгэл ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар тайлант хугацаанд сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй эм боох материалыг 17 аж ахуй нэгжээс худалдан авч орлогоор бүртгэсэн, гэрээ дүгнэж, акт үйлдээгүйтэй холбоотой 31.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Энэ нь Эм эмнэлэгийн хэрэгслийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, дахь заалтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "толилуулга", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан Эрүүл

мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 628.4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад хэсэг

Тус төвийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 17 байхаар баталж, 15 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн "Энэрэнгүй сэтгэл" ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн засаг даргын 2026 оны А/47 захирамжаар 88.9 хувь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 99.2 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,954,087.08	8,566,706.94
1.1.2	Дансны авлага	43,707,739.38	6,732,582.80
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.6	Бараа материал	50,442,788.76	42,616,298.11
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	104,104,615.22	57,915,587.85
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	215,582,975.75	198,425,761.81
1.2.8	Биет бус хөрөнгө	7,064,000.00	7,064,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	222,646,975.75	205,489,761.81
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	326,751,590.97	263,405,349.66
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	940,781.72	-
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	940,781.72	-
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	278,722,881.63	278,722,881.63
2.3.2	Хувийн	5,464,284.36	5,464,284.36
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг	41,623,643.26	(20,781,816.33)
2.3.10	Тайлант үеийн үр дүн		(62,405,459.59)
2.3.11	Эздийн өмчийн дүн	325,810,809.25	263,405,349.66
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	326,751,590.97	263,405,349.66

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	639,860,172.91	591,475,553.60
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	639,860,172.91	591,475,553.60
5	Хүүний орлого	209,049.66	225,455.09
8	Бусад орлого	23,134.674.93	48,825.372.41
10	Ерөнхий ба удирдлагын зардал	671,478,038.56	700,931,840.69
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(8,285,391.06)	(62,405,459.59)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(8,285,391.06)	(62,405,459.59)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(8,285,391.06)	(62,405,459.59)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	(8,285,391.06)	(62,405,459.59)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31	278,722,881.63	5,464,284.36	-	5,464,284.36	334,096,200.31
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	278,722,881.63	5,464,284.36	-	5,464,284.36	334,096,200.31
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(8,285,391.06)	(8,285,391.06)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31	278,722,881.63	5,464,284.36	-	41,623,643.26	325,810,809.25
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	278,722,881.63	5,464,284.36	-	41,623,643.26	325,810,809.25
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(62,405,459.59)	(62,405,459.59)
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт		-			-
Зарласан ногдол ашиг					-
2025 оны 12-р сарын 31	278,722,881.63	5,464,284.36	-	(20,781,816.33)	263,405,349.66

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.0	Мөнгөн орлогын дүн (+)	636,767,002.39	667,896,884.10
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	636,557,952.73	664,716,029.01
1.1.6	Бусад мөнгөн орлого	209,049.66	3,180,855.09
1.2.	Мөнгөн зарлагын дүн (-)	629,474,342.86	664,649,514.24
1.2.1	Ажиллагчдад төлсөн	493,407,579.97	526,100,184.39
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	55,414,913.00	56,519,947.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	48,927,094.50	40,064,849.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	17,454,952.42	18,007,937.32
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,673,000.00	1,614,000.00
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	542,304.00	694,112.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	12,054,498.97	21,648,484.53
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,292,659.53	3,247,369.86
2.	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2.	Мөнгөн зарлагын дүн (-)	9,898,812.00	4,634,750.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,898,812.00	4,634,750.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,898,812.00)	(4,634,750.00)
3.	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4.	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,606,152.47)	(1,387,380.14)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,560,239.55	9,954,087.08
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,954,087.08	8,566,706.94

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй 31,245.8 мянган төгрөгийн эм боох материалыг 17 аж ахуй нэгжээс аудалдан авч, гэрээ дүгнэж, акт үйлдээгүй.	1	31,245.8	-	-	1	31,245.8	-	-	-	-	-	-
Элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн 103 ширхэг 126,761.9 мянган төгрөгийн хөрөнгүүдийг зах зээлийн бодит үнээр үнэлж бүртгээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	2	31,245.8	-	-	1	31,245.8	1	-				